

Хувьцааны бүртгэлд өөрчлөлт  
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 52.2, “АПУ” ХК-ийн 2008 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын 01 тоот тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“АПУ” ХК-ийн нэгж хувьцаа бүрийг 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг хувьцаа болгон хөрвүүлж, уг компанийн нийт гаргасан 742877 ширхэг хувьцааг 74287700 ширхэг болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн үнэт цаасны арилжааг 2008 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс ажлын 5 хүртэл хоногийн хугацаагаар түр зогсоосугай.

3.Бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг дууссаны дараа Хороонд албан бичгээр мэдэгдэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

4.Бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааны хэрэгжилтийг хянаж уг ажиллагааг бүрэн дууссаны дараа энэ тогтоолын 2-т заасан зогсоосон арилжааг сэргээхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ